



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

**ИРГЭДИЙН ИНФЛЯЦЫН  
ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА**  
2024 оны IV улирал

2025 оны 02 дугаар сар




## I. ХУРААНГУЙ

“Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа”-ны мэдээлэл цуглуулах ажлыг 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс 31-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулж, Улаанбаатар хотод оршин суугаа иргэдийн байршил, хүйс, насны бүлэг болон өрхийн орлогын бүтцийн төлөөллийг хангасан нийт 998 иргэний түүвэр судалгааны мэдээллийг боловсруулж, судалгааны үр дүнг дараах байдлаар нэгтгэлээ. Судалгааны товч үр дүнгээс хураангуйлбал:

- Тус түүвэр судалгаанд Баянзүрх болон Сонгинохайрхан дүүрэгт оршин суудаг иргэд 45 хувийг бүрдүүлсэн бөгөөд 26-45 насны дээд боловсролтой иргэд түлхүү оролцлоо. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа эмэгтэй, эрэгтэй харгалзан 60%, 40% байлаа.
- Түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн хариултаас хүлээгдэж буй инфляцыг тооцвол: 2025 оны I улирлын эцэст мэдрэмжид суурилсан инфляцын хүлээлтийн утга **15.1%**, чанарын хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн утга **14.1%**, тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн утга **10.8%**-тай гарлаа. Харин ирэх 12 сард буюу 2025 оны жилийн эцэст инфляц мэдрэмжид суурилсан аргаар **10.9%**, чанарын хариултаас тооцсон аргаар **13.1%**, тоон хариултын жигнэсэн дундаж утга **10.6%**-д хүрэх төлөвтэй байна.
- Өрхийн орлого болон зардлын ирэх улирлын хүлээлт хоёул нэмэгдэхээр байгаа хэдий ч зардлын өсөлт илүү хурдацтай байхаар байна. Улмаар өрхийн санхүүгийн тэнцэл муудах, хуримтлал буурах хүлээлт давамгайлж байна. Ирэх улирлын санхүүгийн байдлын төлөвлөлт хүндрэлтэй байна гэж иргэдийн дийлэнх үзэж байна.
- Ажил эрхлэлтийн хүлээлт өмнөх улирлаас өсөж, ирэх улиралд ажил эрхлэлт нэмэгдэх хүлээлттэй гарлаа. Гэсэн хэдий ч судалгаанд хамрагдсан иргэдийн дунд ирэх улиралд эдийн засаг удаашрах хүлээлт зонхилж, гадаад валютын эсрэг төгрөгийн ханш үргэлжлэн суларна гэж судалгаанд оролцогчдын дийлэнх үзэж байна.
- Зээлийн хүүний хувьд ирэх улиралд хүү өсөх хүлээлт иргэдийн дунд давамгайлж байгаа хэдий ч өмнөх улирлаас бага зэргийн буураад байна.

Зураг 1. Инфляцын хүлээлт




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

## II. ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТ


Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн өгсөн чанарын хариултаар өнгөрсөн хугацааны үнийн өсөлтийн мэдрэмжийн индексийг тооцоход өнгөрсөн 3 болон 12 сарын хугацааны хувьд ялгаагүй бөгөөд өмнөх улирлын судалгааны үр дүнгээс бага зэрэг өсөж, “инфляц өссөн” мужид хэвээр хадгалагдлаа (Зураг 2).

Мөн ирэх хугацааны инфляцын хүлээлтийн индексийг тооцоход ирэх улирлын болон ирэх 1 жилийн хугацааны хүлээлтийн индексийн утга өмнөх улирлаас бага зэргийн буурсан бол өмнөх оны мөн үеийн утгаас нэлээдгүй нэмэгдээд байна (Зураг 3).

Зураг 2. Инфляцын мэдрэмжийн индекс<sup>1</sup>



Зураг 3. Инфляцын хүлээлтийн индекс



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Өнгөрсөн хугацааны инфляцын мэдрэмж (*perceived inflation*)<sup>2</sup> болон ирэх хугацааны хүлээлтийн талаар иргэдийн өгсөн чанарын хариултаас инфляцын утгыг тооцоход 2025 оны эхний улирлын эцэст **15.1%**, 2025 оны жилийн эцэст **10.9%**-д хүрэх хүлээлттэй байна (Зураг 4). Мөн инфляцын хүлээлтийн чанарын хариултаас тооцсон<sup>3</sup> хүлээгдэж буй утга ирэх улиралд **14.1%**, ирэх 12 сард **13.1%**-тай гарлаа (Зураг 5). Харин инфляцын хүлээлтийн талаар тоон утгаар асуусан хариултад тулгуурлан хүлээгдэж буй утгыг тооцоход ирэх улиралд **10.8%**, ирэх 12 сард буюу 2025 оны жилийн эцэст **10.6%**-тай байх төлөвтэй байна (Зураг 6). Эдгээр 3 аргачлалаар тооцсон 2025 оны эхний улирлын эцэс дэх хүлээгдэж буй инфляц хоёр оронтой тоонд хүрэх буюу үнийн өсөлт одоогийн түвшнээс нэлээдгүй нэмэгдэх хүлээлттэй байна. 2023 оноос хойш 6 улирал дараалан буураад байсан хүлээлтийн утга сүүлийн 2 улиралд эрчимтэй нэмэгдэж, 2022 оны ойролцоо түвшинд хүрээд байна.


1 Бараа, үйлчилгээний үнийн ерөнхий түвшин өнгөрсөн хугацаатай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн талаар мэдрэмжийг асууж, “маш ихээр өссөн”, “нэлээдгүй өссөн”, “аажмаар өссөн”, “хэвэндээ” болон “буурсан” гэсэн хариултуудыг [3;-1] утгаар нормчилж чиглэлийн индексийг тооцсон болно.

2 Мэдрэгдсэн инфляцын утгыг [Forsells, Kenny](#) (2002) нарын боловсруулсан аргачлалд тулгуурлан тооцлоо.


3 Инфляцын хүлээлтийн чанарын хариултаас [Carlson, Parkin](#) (1975) нарын боловсруулсан аргачлалыг ашиглан хүлээлтийн утгыг тооцсон болно.

Ирэх 3 болон ирэх 12 сарын инфляцын хүлээлтийн талаар иргэдийн өгсөн тоон хариултын тархалтыг харвал хоёул одоогийн инфляцаас өсөх чиглэлд буюу баруун тийш хазайлттай гарчээ (Зураг 7).


Зураг 4. Мэдрэмжид суурилсан инфляцын хүлээлт




Зураг 5. Чанарын хариултаас тооцсон инфляцын хүлээлт



Зураг 6. Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлт



Зураг 7. Инфляцын хүлээлт, тоон хариултын тархалт




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа


### Ш. ӨРХИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ

Өрхийн орлого 2025 оны I улиралд эерэг утгатай буюу бага зэргийн нэмэгдэх хүлээлттэй гарлаа (Зураг 8). Тухайлбал, өрхийн орлогын хүлээлт өмнөх улирлын судалгааны хүлээлтийн утгаас 0.07 нэгжээр нэмэгдэж, багагүй өсөлт үзүүлсэн нь эерэг үзүүлэлт болж байна. Харин өрхийн зардлын хүлээлт ирэх улиралд эерэг утгатай буюу нэмэгдэх хүлээлттэй байгаа хэдий ч өмнөх 3 улирлуудын утгаас нэлээдгүй буурч, өрхийн зардлын өсөлт саарах хандлагатай байна (Зураг 9). Гэсэн хэдий ч өрхийн зардлын өсөлт нь орлогын өсөлтөөс давахаар буюу илүү хурдацтай байна.

Зураг 8. Өрхийн орлогын хүлээлт, ирэх 3 сар



Зураг 9. Өрхийн зардлын хүлээлт, ирэх 3 сар



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ

Ирэх улиралд өрхүүд хадгаламжаа бууруулах хүлээлт сүүлийн 3 улирал дараалан өндөр хэвээр гарлаа (Зураг 10). Өрхийн орлого бага зэргийн нэмэгдсэн ч өрхийн хэрэглээний өсөлт сүүлийн 4 улирал дараалан өндөр түвшинд хадгалагдсан нь хуримтлал үүсгэх боломжийг хязгаарлажээ. Гэсэн хэдий ч иргэдийн хугацаатай хадгаламж 2024 оны жилийн эцэст 18.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 24 хувиар өсөөд байна. Нөгөө талаас банкуудаас авсан иргэдийн хэрэглээний зээлийн үлдэгдэл 2024 оны эцэст 11.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 36 хувиар өсжээ.


Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-оос эрхлэн гаргадаг “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа”-ны 2024 оны IV улирлын нэрлэсэн дүнгээрх өрхийн дундаж орлого болон зардлын зөрүүгээр өрхийн санхүүгийн тэнцэл 79.6 мянган төгрөгийн алдагдалтай гарч байна. Өөрөөр хэлбэл, өрхүүд өөрсдийн хэрэглээгээ хуримтлалаасаа илүүтэйгээр зээлээр санхүүжүүлж байна.

Ирэх улиралд санхүүгийн нөхцөл байдлаа төлөвлөхөд ямар байх талаар иргэдээс тодруулахад судалгаанд оролцогчдын дийлэнх нь санхүүгийн байдлаа төлөвлөхөд хүндрэлтэй байгаа талаар дурджээ. Өөрөөр хэлбэл, энэхүү үзүүлэлт нь ирэх хугацааны эдийн засгийн тодорхой бус байдлыг илтгэх бөгөөд ирэх улиралд тодорхой бус байдал өндөр байх хүлээлттэй байна (Зураг 11).


Иргэдийн банкнаас авсан хэрэглээний зээлийн үлдэгдэл, түүний жигнэсэн дундаж хүү болон хугацаагаар зээлийн сарын дундаж төлбөрийг тооцоход 2024 оны эцсийн байдлаар 602.2 мянган

төгрөг болж байна. Энэ нь өрхийн сарын дундаж нэрлэсэн орлогын 23 хувьтай тэнцэх бөгөөд энэхүү үзүүлэлт сүүлийн 1 жилийн хугацаанд тасралтгүй нэмэгдсээр байна.

Зураг 10. Өрхийн хадгаламжийн хүлээлт, ирэх 3 сар



Зураг 11. Санхүүгийн байдлын төлөвлөлт, ирэх 3 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, Монголбанк, ҮСХ


#### IV. ИРГЭДИЙН МАКРО ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХҮЛЭЭЛТ

Ажил эрхлэлтийн үзүүлэлт өмнөх улирлын утгаас эрс нэмэгдэж, ирэх улиралд ажил эрхлэлт бага зэрэг нэмэгдэх хүлээлт давамгайллаа (Зураг 12). Гэсэн хэдий ч ҮСХ-оос зарласан ажиллагчдын тооны өсөлт сүүлийн 4 улиралд дараалан буураад байна. Мөн эдийн засгийн өсөлтийн талаар хүлээлтийн үзүүлэлтийг тооцоход -0.17 утгатай буюу эдийн засаг агших хүлээлттэй гарлаа (Зураг 13). Хүлээлтийн үзүүлэлтийг өмнөх улирлын утгатай харьцуулахад бага зэргийн өсөлттэй байгаа нь эерэг үзүүлэлт болж байна.

Зураг 12. Ажил эрхлэлтийн хүлээлт, ирэх 3 сар



Зураг 13. Эдийн засгийн байдлын талаарх хүлээлт, ирэх 3 сар





Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ

2024 оны IV улиралд 1 ам.доллар дунджаар 3,408 төгрөгтэй тэнцэж, өмнөх оны мөн үеэс 1 хувиар чангарсан хэдий ч гадаад валютын эсрэг төгрөгийн ханш ирэх улиралд үргэлжлэн суларна гэж иргэд үзэж байна (Зураг 14).

Зээлийн хүүний хувьд ирэх улиралд хүү өсөх хүлээлт иргэдийн дунд давамгайлж байгаа хэдий ч өмнөх улирлаас бага зэргийн буураад байна (Зураг 15). Иргэдэд олгосон банкны хэрэглээний зээлийн жигнэсэн дундаж хүү сүүлийн 2 жилд төдийлөн өөрчлөлт ороогүй буюу 2024 оны IV улиралд иргэдэд олгосон хэрэглээний зээлийн жигнэсэн дундаж хүү 17.0%-тай байна.

Зураг 14. Гадаад валютын ханшийн хүлээлт, ирэх 3 сар

Зураг 15. Зээлийн хүүний талаарх хүлээлт, ирэх 3 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, Монголбанк


## V. ХАВСРАЛТ

“Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа”-ний мэдээлэл цуглуулах ажлыг 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс 31-ний өдрийг дуустал хугацаанд Улаанбаатар хотод оршин суугаа насанд хүрсэн иргэдийн дунд зохион байгуулж, утсаар ярилцлага хийх байдлаар нийт 1,001 иргэний мэдээллийг цуглууллаа. Үүнээс давхардсан судалгааны мэдээллийг хассанаар судалгаанд оролцсон 998 иргэд нь эх олонлогоо бүрэн төлөөлөх чадвартай байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын оршин суугаа хаягийг ҮСХ-оос зарласан 2023 онд Улаанбаатарт оршин суугаа жилийн дундаж хүн ам (насанд хүрэгч иргэд)-ын бүтэцтэй харьцуулахад харгалзан пропорциональ байна (Зураг 16). Баянзүрх болон Сонгинохайрхан дүүргийн иргэд судалгаанд оролцогчдын 45 хувийг бүрдүүлсэн бол энэ удаагийн судалгаанд оролцогчдын 60% нь эрэгтэй, 40% нь эмэгтэй байна (Зураг 17).

Зураг 16. Судалгаанд оролцогчдын оршин суугаа хаяг




Зураг 17. Судалгаанд оролцогчдын хүйс




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ

Мөн судалгаанд оролцогчдыг насны ангиллаар харвал 55-с дээш болон 36-45 насны хүмүүс 63 хувийг бүрдүүлэх бөгөөд боловсролын хувьд дээд болон бүрэн дунд боловсролтой иргэд түлхүү оролцлоо (Зураг 18-Зураг 19).

Зураг 18. Судалгаанд оролцогчдын насны ангилал



Зураг 19. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ




Харин энэ удаагийн судалгаанд тэтгэвэрт болон хувийн байгууллагад ажилладаг иргэд голлон хамрагдлаа (Зураг 20). Судалгаанд оролцогч иргэдийн өрхийн орлогын бүлэглэлт нь ҮСХ-оос зохион байгуулдаг “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа”-ны өрхүүдийг мөнгөн орлогоор бүлэглэсэн хамгийн сүүлийн буюу 2024 оны IV улирлын үр дүнтэй нийцтэй байна (Зураг 21).

Зураг 20. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлт



Зураг 21. Судалгаанд оролцогчдын орлогын бүлэглэлт



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ